

**НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦ БОЛОН САНХҮҮ,
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2017.08.31

Улаанбаатар хот

/2017 оны эхний 8 сарын байдлаар/

**НЭГ. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 5/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-д 334 арга хэмжээг нийслэлийн нутгийн захиргааны 52 байгууллага хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Зорилт	Зорилтын тоо	Нийт заалтын тоо	Эзлэх хувийн жин
1. Эдийн засгийн өсөлт –Өрх бүрт	6	45	13.5
2. Хот байгуулалт, дэд бүтэц	5	76	23
3. Байгаль орчин, ногоон хөгжил	3	45	13.5
4. Нийгмийн хөгжил	8	115	34
5. Засаглал	4	53	16
НИЙТ	26	334	100

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 334 ажлын хувьд “Нийгмийн хөгжил” зорилтын хүрээнд 115 ажил буюу нийт ажлын 34 хувь, “Эдийн засгийн өсөлт-Өрх бүрт” зорилт, “Байгаль орчин, ногоон хөгжил” зорилтын хүрээнд тус бүр 45 ажил буюу нийт ажлын 13.5 хувийг хийхээр төлөвлөсөн.

Нийслэлийн эдийг засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт хагас жилийн байдлаар 46.7 хувьтай байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийг засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 25 дэд хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Дэд хөтөлбөрийн боловсруулалтын хувьд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 8, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулахаар өргөн барьсан 3, боловсруулалтын шатандаа байгаа 14 хөтөлбөр байна.

№	Дэд хөтөлбөрийн нэр	Батлагдсан огноо, дугаар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
<i>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан:</i>				
1.	“Теле камер” дэд хөтөлбөр	2017.04.18 № 62	2017-2020 он	НЦГ, Дүүргүүд
2.	“Гэмт хэргийн хяналтын цогц систем” дэд хөтөлбөр	2017.04.18 № 62	2017-2020 он	НЦГ, Дүүргүүд
3.	“Эргүүл” дэд хөтөлбөр	2017.04.18	2017-2020 он	НЦГ,

		№ 62		Дүүргүүд
4.	“Нэг өрх-Нэг ажлын байр” дэд хөтөлбөр	2017.04.18 № 71	2017-2020 он	НХЭГ, НХГ, Дүүргүүд
5.	“Боловсрол-2020” дэд хөтөлбөр	2017.05.30 № 81	2017-2020 он	НБГ, Дүүргүүд
6.	“Нийслэлийн эрүүл мэнд” дэд хөтөлбөр	2017.06.07 № 89	2017-2020 он	НЭМГ, Дүүргүүд
7.	“Улаанбаатарт үйлдвэрлэв” дэд хөтөлбөр	2017.06.22 № 100	2017-2020 он	ЖДҮДТ, НҮИГ
8.	“Хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр	2017.06.22 № 103	2017-2020 он	НХГБХГ, НЭМГ, НБГ, НСУГ
<i>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулахаар өргөн барьсан:</i>				
1.	“Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр		2017-2020 он	НСУГ
2.	“Орон нутгийн үйлдвэрлэлийн түншлэл” дэд хөтөлбөр		2017-2020 он	НҮИГ, ЖДҮДТ
3.	Нийслэлийн орон сууц, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр		2017-2020 он	УБЗАА, НХТЕТГ, НГХДБГ, НОСК
<i>Шинээр боловсруулах:</i>				
1.	Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр	-	2017-2020 он	НАЖГ
2.	“Шөнийн Улаанбаатар” дэд хөтөлбөр	-	2017-2020 он	НАЖГ, НСУГ, НЦГ
3.	Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр	-	2017-2020 он	ННБТСХ
4.	Нийслэлийн залуучуудын хөгжлийн хөтөлбөр	-	2017-2020 он	НЗХГ
5.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих нийслэлийн дэд хөтөлбөр	-	2017-2020 он	НХГ
6.	Улаанбаатар хотын хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах хөтөлбөр	Хугацаа дууссан тул шинэчлэх /2014.09.22 № 19/22/	2017-2020 он /2014 – 2016 он/	УБЗАА, УСУГ
7.	Эрсдэлийн удирдлага болон гамшгийн менежментийн үйл ажиллагааны хөтөлбөр	-	2017-2020 он	НЗДТГ-ын БТХ, НОБГ
8.	Нийслэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах дунд хугацааны хөтөлбөр	-	2017-2020 он	УБЗАА
9.	Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ – 2020 дэд хөтөлбөр	-	2017-2020 он	УБЗАА
10.	Хүн амын ахуйн үйлчилгээ – 2020 дэд хөтөлбөр	-	2017-2020 он	УБЗАА
11.	Дулаан техникийн шинэчлэлт хөтөлбөр	-	2017-2020 он	УБЗАА
12.	Авто зогсоол дэд хөтөлбөр	-	2017-2020 он	НАЗХГ
13.	Улаанбаатар хотын такси үйлчилгээний хөтөлбөр	-	2017-2020 он	НТЭГ

14.	Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр	-	2017-2020 он	НЗДТГ-ын ТЗУХ
-----	---	---	--------------	---------------

ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР

Нийслэл, дүүргийн 2017 оны орон нутгийн төсөвт нийт 718.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, нийт 781.4 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлж мөн Төсвийн тухай хуулийн дагуу нийслэлийн төсвөөс Улсын төсөвт 159.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр хуульчлан батлагдсан.

Нийслэлийн төсвөөс Сонгинохайрхан, Багануур, Налайх, Багахангай дүүргүүдэд нийт 13.8 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүд нийслэлийн төсөвт 82.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан.

Нийслэлийн 2017 оны эхний 8 сарын орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Төсвийн орлогын талаар: 2017 оны эхний 7 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нийслэлийн төсөвт 562.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсний 368.6 тэрбум төгрөгийн орлого нь хууль тогтоомжийн дагуу нийслэлийн төсөвт төвлөрч буй төсвийн орлогоос, 188.2 тэрбум төгрөгийн орлого нь улсын төсвөөс хууль тогтоомжийн дагуу нийслэлд олгож байгаа тусгай зориулалтын шилжүүлгээс, 5.7 тэрбум төгрөгийн орлого нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн орлогоос тус тус бүрдэж байна.

Төсвийн орлогын төлөвлөгөө нийслэлийн дүнгээр 17 тэрбум 806,8 сая төгрөгөөр буюу 4,6 хувиар тасарснаас Чингэлтэй, Багануур, Налайх дүүргүүд төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, бусад дүүргүүд болон хотын шуудын төсвийн орлогын бүрдүүлэлт тасалдсан дүнтэй байна.

Нийслэлийн төсвийн орлогын 2017 оны 7 дугаар сарын гүйцэтгэл

№	Хот дүүрэг	2017 оны батлагдсан төлөвлөгөө	2017 оны 7 сар /мян.төг/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Хувь
1	Хотын шууд	535,809,443.9	296,964,149.6	273,446,050.9	(23,518,098.7)	92.1
2	Баянгол дүүрэг	18,678,566.0	9,835,005.7	9,113,854.7	(721,151.0)	92.7
3	Баянзүрх дүүрэг	19,442,762.0	11,122,985.0	10,151,971.4	(971,013.6)	91.3
4	Хан-Уул дүүрэг	20,260,350.0	11,774,569.1	10,643,782.4	(1,130,786.7)	90.4
5	Чингэлтэй дүүрэг	55,228,042.2	28,378,817.1	38,350,638.6	9,971,821.5	135.1
6	Сүхбаатар дүүрэг	59,155,952.1	22,349,331.6	21,314,840.2	(1,034,491.4)	95.4
7	Сонгинохайрхан дүүрэг	7,700,000.0	4,613,000.0	3,977,846.3	(635,153.7)	86.2
8	Багануур дүүрэг	1,151,636.0	684,066.5	759,317.1	75,250.6	111.0
9	Багахангай дүүрэг	187,600.0	106,050.0	101,505.2	(4,544.8)	95.7
10	Налайх дүүрэг	1,028,400.0	606,650.0	767,980.6	161,330.6	126.6
Нийт дүн		718,642,752.2	386,434,624.6	368,627,787.3	(17,806,837.3)	95.4

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн баталдаг хотын шуудын төсвийн хувьд 2017 оны 7 дугаар сарын гүйцэтгэлээр нийтдээ 273 тэрбум 446,1 сая төгрөгийн орлого төвлөрч, төсвийн орлогын төлөвлөгөө 23,5 тэрбум төгрөгөөр буюу 7.9 хувиар тасарсан байна.

Хотын шуудын төсвийн орлогын төлөвлөгөөний тасалдлыг орлого бүрдүүлэгч байгууллагаар нь задлан авч үзвэл, нийслэлийн Татварын газар 2,9 тэрбум төгрөгөөр буюу 1,2 хувиар, Өмчийн харилцааны газар 7,7 тэрбум төгрөгөөр буюу 87,2 хувиар, нийслэлийн Газрын алба 6,8 тэрбум төгрөгөөр буюу 24,7 хувиар, Авто замын хөгжлийн газар 1,5 тэрбум төгрөгөөр буюу 13,8 хувиар, Улаанбаатар зам засвар арчлалт НӨҮГ 67,0 сая төгрөгөөр буюу 100 хувь тус тус төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна.

Хотын шуудын төсвийн орлогын
2017 оны 7 дугаар сарын гүйцэтгэл /байгууллагаар/

/мян.төг/

№	Орлого бүрдүүлэгч байгууллагууд	2017 оны 7 сар		Биелэлт	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давалт, тасралт	Хувь
1	Нийслэлийн Татварын газар	252,705,879.1	249,714,802.1	(2,991,077.0)	98.8
2	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	8,860,000.0	1,136,586.2	(7,723,413.8)	12.8
3	Нийслэлийн Газрын алба	27,700,000.0	20,853,455.4	(6,846,544.6)	75.3
4	Нийслэлийн Байгаль орчны газар	120,000.0	146,331.4	26,331.4	121.9
5	Замын цагдаагийн газар	7,000,000.0	7,979,535.7	979,535.7	114.0
6	Нийслэлийн Цагдаагийн газар	641,662.0	725,655.4	83,993.4	113.1
7	Нийслэлийн Онцгой байдлын газар	35,500.0	59,725.4	24,225.4	168.2
8	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	620,000.0	1,035,840.8	415,840.8	167.1
9	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар	204,166.5	29,892.6	(174,273.9)	14.6
10	Авто замын хөгжлийн газар	11,278,350.0	9,723,411.2	(1,554,938.8)	86.2
11	Улаанбаатар хотын зам засвар арчлалт	67,000.0	-	(67,000.0)	-
12	Замын хөдөлгөөний удирдлагын төв	1,850,000.0	2,246,449.7	396,449.7	121.4
13	Нийслэлийн Аудитын газар	220,000.0	293,086.6	73,086.6	133.2
14	Дотоод Аудитын алба	5,000.0	23,620.7	18,620.7	472.4
15	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,656,592.0	4,466,954.3	(8,189,637.7)	35.3
16	ХХОАТ-ын буцаан олголт	(27,000,000.0)	(25,393,036.4)	1,606,963.6	94.0
17	Бусад		403739.7	403,739.7	
Нийт дүн		296,964,149.6	273,446,050.8	(23,518,098.8)	92.1

2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийслэлийн төсөвт 314.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, төсвийн орлогын төлөвлөгөө 24.2 тэрбум төгрөгөөр буюу 7.2 хувиар тасрах урьдчилсан дүнтэй байна.

Төсвийн зарлагын талаар: Нийслэл, дүүргийн орон нутгийн төсвөөс 2017 оны эхний 8 сард 525.6 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийхээр төлөвлөснөөс 285.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Нийт төсвийн зарлагын гүйцэтгэлийн 59.5 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардалд, 46.8 тэрбум төгрөгийг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих

иргэдийн нөхөн олговор, нийтийн тээврийн үйлчилгээний машин цагийн зардалд, 2.3 тэрбум төгрөгийг Нийслэлийн Засаг даргын даргын нөөц хөрөнгийн зардалд, 18.8 тэрбум төгрөгийг хот, нийтийн аж ахуй тохижилт үйлчилгээний зардалд, 3.3 тэрбум төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд, 97.2 тэрбум төгрөгийг төсвийн байгууллагын ажиллагсдын цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон бусад урсгал зардалд, 57.2 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн дагуу 2017 оны эхний 8 сарын байдлаар нийслэлийн төсвөөс Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 64,4 тэрбум төгрөгийг 100 хувь, дүүргүүдийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 9.2 тэрбум төгрөгийг 100 хувь тус тус олгосон. Дүүргүүдийн төсвөөс нийслэлийн төсөвт 39.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 34.4 тэрбум төгрөг төвлөрч, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг 5.3 тэрбум төгрөг буюу 13.2 хувийг дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын талаар : Нийслэлд 2017 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 162 тэрбум 42.5 сая төгрөгийн, нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 35 тэрбум 808,4 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 11 тэрбум 822.5 сая төгрөгийн, нийт 209 тэрбум 673.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбараар нь авч үзвэл:

/сая төг/			
№	Хөрөнгө оруулалт /салбараар/	Төсөвт өртөг	Эзлэх хувь
1	Нийгмийн салбар	21,927.0	11.1
2	Хот байгуулалт, дэд бүтцийн салбар	110,220.5	55.7
3	Авто замын салбар	44,939.3	22.7
4	Байгаль орчин, хот тохижилтын салбар	15,505.2	7.8
5	Төрийн үйлчилгээг сайжруулах	5,258.8	2.7
ДҮН		197,850.9	100.0

Нийгмийн салбарт 21 тэрбум 927,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 11 тэрбум 609,3 сая төгрөгийг боловсролын салбарт, 5 тэрбум 125.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн салбарт, 5 тэрбум 192.6 сая төгрөгийг нийгмийн халамжийн салбарт тус тус зарцуулахаар;

Хот байгуулалтын салбарт 110 тэрбум 220,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр;

Авто замын салбарт нийслэлийн төсөв, нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 44 тэрбум 939,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр;

Хот тохижилт, байгаль орчны салбарт нийслэлийн төсвөөс 2017 онд 15 тэрбум 505,2 сая төгрөгийг зарцуулж хот тохижилтын тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжөөр хангах ажилд 1 тэрбум 500,0 сая, нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийг сайжруулахад 2,0 тэрбум, зам талбайн гэрэлтүүлгийг нэгдсэн удирдлагын системд холбоход 1,0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулахаар;

Төрийн үйлчилгээг сайжруулахад 5 тэрбум 258,8 сая төгрөгийг зарцуулан Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт цагдаагийн хэлтсийн барилга, Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороонд Аврах гал унтраах ангийн барилгыг барьж, нийслэлийн нэгдсэн сүлжээний дэд

бүтцийг өргөтгөн, хорооноос үзүүлэх цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан сүлжээг бий болгохоор тус тус төлөвлөсөн.

2017 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 197,8 тэрбум төгрөг, 2017 он дамжин санхүүжүүлэхээр 13.3 тэрбум төгрөг буюу нийт 211.1 тэрбум төгрөгийн 912 нэр төрлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ санхүүжихээр батлагдсанаас 8 дугаар сарын байдлаар гэрээ байгуулсан буюу захиалагч байгууллагуудын хянан, баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэлийг үндэслэн 57.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн дүн /2017.08.31-ний өдрийн байдлаар/

/сая төгрөг/				
№	Эх үүсвэр	Ажлын тоо	2017 онд санхүүжих	Олгосон санхүүжилт
1	Нийслэлийн төсөв	854	197,850.9	48,186.4
2	Нийслэлийн төсөв /2017 он дамжин санхүүжих/	58	13,288.3	9,054.3
Нийт дүн		912	211,139.2	57,240.7

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын талаар:

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2013 оны 244 дүгээр тушаал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 6/11 дүгээр тогтоолын дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг НИТХ-аас зохион байгуулсан “Иргэдээ сонсьё” аяны хүрээнд иргэдээс гарсан санал, НИТХ-ын Төлөөлөгчдийн саналын дагуу хуваарилсан.

УИХ-аас баталсан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас нийслэлд олгосон 11 тэрбум 822,5 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг Засгийн газрын тогтоолын дагуу хүн амын тоо, нягтрал, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилгын индекс зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан дүүрэг бүрээр хуваарилан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 10/13 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

Дээрх орлогоос нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд 8 тэрбум 371.4 сая төгрөгийн хөрөнгө хуваарилагдсаныг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн.

Үүнд:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас зохион байгуулсан “Иргэдээ сонсьё” аяны дүнд гарсан санал, НИТХ-ын Төлөөлөгчдөөс ирүүлсэн саналыг хэрэгжүүлэхэд 4 тэрбум 559.0 сая төгрөгийг;

2. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11 дэх заалтыг үндэслэн Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээ, тандалт, шинжилгээ, оношилгоо, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд 319.0 сая төгрөгийг;

3. Нийслэлийн удирдлагаас орон нутагт ажиллах үеэр иргэдээс ирсэн санал, хүсэлтийг хэрэгжүүлэхэд 3,493.4 сая төгрөг тус тус зарцуулна.

2017 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд 11,8 тэрбум төгрөг олгохоор батлагдсан. 2017 оны эхний 8 сарын байдлаар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 8.0 тэрбум төгрөг олгохоор батлагдсанаас 7.3 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлэг ирснийг дүүргүүдэд батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу бүрэн олгосон.

2017 оны 8 дугаар сарын байдлаар олгосон ОНХСангийн
санхүүжилтийн товъёог /сая.төг/

№	Дүүргүүд	2017 онд санхүүжих	ОНХНС-аас шилжиж ирсэн	Олгосон санхүүжилт
	ХОТЫН ШУУД	8,371.5	5,411.8	1,671.2
1	БАЯНГОЛ ДҮҮРЭГ	332.5	166.3	166.3
2	БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ	718.0	359.5	359.5
3	СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ	694.5	348.8	348.8
4	СҮХБААТАР ДҮҮРЭГ	302.1	151.3	151.3
5	ХАН-УУЛ ДҮҮРЭГ	289.6	151.9	151.9
6	ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ	380.5	190.3	190.3
7	БАГАНУУР ДҮҮРЭГ	280.7	279.3	279.3
8	БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ	150.1	75.9	75.9
9	НАЛАЙХ ДҮҮРЭГ	303.1	158.4	158.4
	НИЙТ ДҮН	11,822.6	7,293.7	3,552.9

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар: Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд нийслэлд 139 тэрбум 486.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан.

Үүнд : 345 ор бүхий цэцэрлэгийн 3 барилга, 7800 суудал бүхий 11 сургуулийн барилга барих, 700-1000 хүний суудал бүхий спорт цогцолборын барилгыг 5 дүүрэгт барих, гэр хорооллын хүчдэлийн уналттай болон цахилгаангүй айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, “Гудамж” төслийн хүрээнд он дамжин хэрэгжиж байсан авто замуудыг үргэлжлүүлэн, Орбитын уулзвараас Толгойтын эцэс Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх 3.6 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.

Монгол Улсын Ерөнхий сайд болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаас Нийслэлийн Засаг даргад худалдан авах ажиллагааны эрх нь шилжин ирсэн улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 28 ажилд 4,9 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс 8 дугаар сарын байдлаар захиалагч байгууллагуудаас хянан баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэлийг үндэслэн Сангийн яаманд албан бичиг хүргүүлснээр 753,2 сая төгрөгийн санхүүжилт шилжиж ирснийг холбогдох байгууллагуудын хөрөнгө оруулалтын дансанд бүрэн олгосон.

Концессын гэрээний эргэн төлөлтийн талаар: 2015-2016 онуудад нийт 16 төсөл, арга хэмжээний /ажлын/ 77,4 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдсанаас 29,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон ба концессын гэрээний эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2017 онд нийслэлийн санхүү, төсвийн боломжит эх үүсвэрийн хүрээнд 19,5 тэрбум төгрөгийг төлөхөөр нийслэлийн 2017 оны төсөвт батлагдсанаас 16.3 тэрбум төгрөгийг олгоод байна.

**ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН 2017-2018 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН
БЭЛТГЭЛ АЖЛЫН ТАЛААР**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 186 дугаар тогтоол, “Төв, суурин газрын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 187 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар албан даалгавар гарч хэрэгжилт үр дүнг тооцон, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллалаа.

Улаанбаатар хотын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан нийслэлийн 3 сургууль, 6 цэцэрлэг, 1 хүүхдийн эмнэлгийн гадна болон дотор инженерийн шугам, сүлжээ, дээврийн засвар, шинэчлэлтийн ажилд Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 581.1 сая төгрөгийг олгосон.

Нийслэлийн хэмжээнд 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нийт 1225 арга хэмжээг төлөвлөж, 72 хувийн гүйцэтгэлтэй байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц дулаан цахилгааны эх үүсвэрээр

/2017.08.28-ны өдрийн байдлаар/

№	Эрчим хүчний эх үүсвэр	Засварын ажлын төрөл	Тоо хэмжээ	Гүйцэтгэлийн хувь
1	“Дулааны II цахилгаан станц” ТӨХК	Их болон дунд засвар	43	75%
		Үндсэн болон туслах тоноглол	19	
		Хөрөнгө оруулалт	10	
		Техник зохион байгуулалтын арга хэмжээ	8	
		Барилгын засвар	14	
2	“Дулааны III цахилгаан станц” ТӨХК	Их болон дунд засвар	44	77%
		Үндсэн болон туслах тоноглол	8	
		Хөрөнгө оруулалт	23	
		Техник зохион байгуулалтын арга хэмжээ	68	
		Барилгын засвар	8	
3	“Дулааны IV цахилгаан станц” ТӨХК	Их засвар	11	76%
		Үндсэн болон туслах тоноглол	25	
		Хөрөнгө оруулалт	24	
		Техник зохион байгуулалтын арга хэмжээ	9	
4	“Амгалан” дулааны станц	Их болон урсгал засварын ажил	22	85%
Гүйцэтгэлийн дундаж хувь				78,2%

Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц салбар хариуцсан байгууллагуудаар

/2017.08.28-ны өдрийн байдлаар/

№	Байгууллагын нэр	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлтийн хувь
Инженерийн хангамжийн байгууллагууд			
1	Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК	61	80
2	Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	42	77
3	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	162	72
4	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК	32	89
5	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар	72	70
6	Ус сувгийн удирдах газар	50	74

7	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар	10	80
8	Замын хөдөлгөөний удирдлагын төв	6	70
Нийт		435	76.5
Хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар			
1	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар	89	55
2	Нийслэлийн Тээврийн газар	14	70
3	Нийслэлийн Боловсролын газар	33	75
4	Геодези, усны барилга байгууламжийн газар	6	80
5	Хот тохижилтын газар	72	70
6	Улаанбаатар зам, засвар арчлалтын газар	6	74
7	Улаанбаатар лифт	5	80
Нийт		236	72
Дүүргүүд			
1	Багахангай дүүрэг	18	52
2	Баянгол дүүрэг	11	70
3	Налайх дүүрэг	33	77
4	Сонгинохайрхан дүүрэг	43	63
5	Чингэлтэй дүүрэг	18	72
6	Баянзүрх дүүрэг	216	55
7	Сүхбаатар дүүрэг	38	60
8	Хан-уул дүүрэг	32	80
9	Багануур дүүрэг	13	60
Нийт		422	65.4

Давс, бодисын нөөцлөлт: 2017-2018 онд өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 1000 тонн бодис, 1500 тонн давс нэмж нөөцлөхөөр 555,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулж байна.

Д/д	Нөөцлөлтийн байдал	ДАВС /тонн/	БОДИС /тонн/
1	2016-2017 оны нөөцөлсөн байдал	2932,6	1735
2	Нөөцөд байгаа /үлдэгдэл/	1295,8	751,7
3	2017-2018 онд нэмж нөөцлөх шаардлагатай, хөрөнгө шийдэгдсэн.	1500,0	1000,0
Нийт		2795,8	1751,7

ДӨРӨВ. 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТАЛААР

Сургуулийн өмнөх боловсрол: 2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих 2-5 насны 146295 хүүхэд байна. Нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн 227, төрийн бус өмчийн 443, нийт 670 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж 113597 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 77,6 хувьтай байна.

Энэ нь өнгөрсөн хичээлийн жилээс 5,6 хувиар хамран сургалт өсөж байна. Жил бүр хамран сургалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 5 байгууллагын дэргэд 16 бүлэгт 425 хүүхэд хамрагдах боломж бүрдсэн. Цэцэрлэгт 11343 орчим багш ажилтан ажиллахаар байна.

Улс, нийслэл, дүүрэг, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 2017 онд нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн 13 цэцэрлэг, цэцэрлэгийн өргөтгөл шинээр ашиглалтад орж 1540 ор, төрийн бус өмчийн 36 цэцэрлэг ашиглалтад орж 2266 ор, нийт 3806 орны хүчин чадал шинээр нэмэгдсэн.

Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах 2 настай хүүхдийн бүртгэлийг онлайн аар бүртгэн элсэлтийг цахимаар санамсаргүй түүврийн аргаар ил тод,

нээлтэй байдлаар эцэг эхчүүдийн оролцоотой зохион байгууллаа. "Цахим бүртгэл"-д бүртгүүлбэл зохих нийт 39347 хүүхдийн 57.4 хувь буюу 22607 нь хамрагдсан. Бүртгэлд хамрагдсан нийт хүүхдийн 47 хувь буюу 10623 хүүхдийг цахимаар элсүүлээд байна.

Ерөнхий боловсролын сургууль: 2017-2018 оны хичээлийн жилд төрийн өмчийн 136, төрийн бус өмчийн 105, нийт 241 сургуульд нийт 249593 суралцагч хамрагдана. Шинээр 1-р ангид 31110 орчим хүүхэд элсэн суралцахаар бүртгэгдээд байна. Мөн 3 ээлжээр хичээллэж буй сургуулийн тоо 3-аар буурч байна.

2017 онд нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн 10 сургууль, сургуулийн өргөтгөл шинээр ашиглалтад орж 7480 суудал, төрийн бус өмчийн 11 сургуульд 3200 суудал ашиглалтад орсноор нийт 10680 суудлын хүчин чадал шинээр нэмэгдлээ.

Улсын төсвөөр 19, нийслэлийн төсвөөр 32 нийт 51 сургууль, цэцэрлэгийн засвар, тохижилтын ажилд нийт 2 728,9 /сая.төг/ төгрөг зарцуулан гүйцэтгэсэн.

2017-2018 оны хичээлийн жилд боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, сургалтын орчныг сайжруулах, чадварлаг боловсон хүчнээр хангах, удирдах ажилтан, багш нарын ажлын хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх зорилтыг тодорхойлж "Багшийн ёс зүй, харилцаа" сургалтыг заах 345 сургагч багшийг бэлтгэн 13000 багшид уг сургалтыг зохион байгууллаа. Ингэснээр боловсролын салбарын багш ажилтны ажлын хариуцлага дээшилж ёс зүйн зөрчил, доголдлоос урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлж байна.

Бүрэн дунд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйг эзэмшүүлэх үндэсний сургагч багш 72, нийслэлийн сургагч 327 багшийг бэлтгэн ахлах ангийн 1900 багшийг сургалтад хамруулснаар ахлах ангийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангалаа.

ТАВ. НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ЖИЛИЙН АЖЛЫН ТАЛААР

5.1 Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, танилцуулга, хэлэлцүүлгийн явцын талаар

Төслийн танилцуулга: УИХ-аас 1994 онд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргасан ч өнөөгийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж, зохицуулж чадахгүй байгаагаас үүдэн хуулийн төслийг боловсруулсан. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 14 бүлэг, 49 зүйлтэй бөгөөд төсөлд зарчмын шинжтэй дараах өөрчлөлтийг тусгасан:

- Нийслэлийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг тодорхой болгосон;
- Нийслэлийн удирдлага, зохицуулалтын үндсэн зарчмыг шинээр томъёолсон;
- Нийслэлийн оршин суугчийн эрх, үүрэг, нийслэлийн нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааг тодорхойлсон;
- Нийслэлийн талаарх төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрхийг цогц байдлаар тодорхойлсон;
- Дүүргийг эдийн засаг, нийгмийн цогцолборын хувьд аймагтай адилтган үзсэн;
- Нийслэлийн хэт төвлөрлийг сааруулж, олон төвт хот байгуулах, дэд төв, дагуул хотуудыг хөгжүүлэх үйл ажиллагааг татварын бодлогоор зохицуулах боломжийг бүрдүүлсэн;
- Газрын бирж байгуулах, үнэт цаас гаргах гаргах зэрэг нийслэл хотын чадавхыг нэмэгдүүлэх асуудлыг зохицуулсан;
- Хот тохижилт, ногоон байгууламж, авто замын сүлжээ, авто тээвэр, төрийн үйлчилгээ, дэд бүтцийн чиглэлээр нийслэлийн удирдлагын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлж, төрийн зарим чиг үүргээ аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжийг бүрдүүлсэн гэх мэт.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай нийцсэн бөгөөд уг төсөлтэй холбогдуулан 12 хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Мөн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээ, зардлын тооцоо, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх тайланг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу боловсруулж хийсэн.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн байдал: Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс www.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж хагас жилийн иргэдээр хэлэлцүүлж, санал авах ажлыг зохион байгуулсан. НЗДТГ-аас уг хуулийн төслөөр дараах хэлэлцүүлгийг зохион байгуулсан:

1. 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 14.00 цагаас Хангарди ордны 14 давхрын хуралдааны их танхимд удирдах ажилтнуудаар төслийг хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлэгт НИТХ-ын төлөөлөгчид, нийслэл, дүүргийн ЗДТГ, хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрын дарга, удирдлага нийт 100 гаруй хүн оролцож, 15 албан хаагч саналаа өгсөн.
2. 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 10.00 цагт Нийслэлийн иргэний танхимд иргэдээр хэлэлцүүлсэн. Уг хэлэлцүүлэгт нийслэлийн 9 дүүргийн 152 хорооны төлөөлөл 450 иргэн оролцож, хуулийн төсөлтэй танилцаж, 20 гаруй иргэн саналаа өгсөн.
3. Нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас тухайн дүүрэгтээ иргэдийн дунд болон төрийн албан хаагчдын дунд хуулийн төслийн танилцуулгыг хийж, хэлэлцүүлсэн байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явц: Хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан.

Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох хуулийн төслүүдийг хэлэлцэхээр дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээд байна.

5.2 "Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн нийгэм эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлыг тодорхой болгох, үр нөлөөтэй, хүртээмжтэй, хариуцлагатай хотын засаглалыг бэхжүүлж нийслэлээс үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, шийдвэр гаргах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2017 оныг "Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил" болгон зарлаж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төлөвлөгөөний биелэлтийг III улирлын байдлаар авч үзвэл:

1. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэрэгжилт 74.9 хувьтай байгаа ба үүнээс 13 хуулийн төслийг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, 6 хуулийн төслийг боловсруулах, санал өгөх ажил хийгдэж байна.
2. Захиргааны хэм хэмжээний актын төсөл, төслийн санал өгөх ажлын хүрээнд "Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөр боловсруулж батлуулах, Газрын суурь үнийг зах зээлийн үнэд нийцүүлэх зайлшгүй шаардлагатай уялдуулан "Газрын зэрэглэл, тэдгээрийн нэг гектарын суурь үнэлгээ, жилийн төлбөрийн дээд, доод хязгаар"-ыг тогтоосон Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэх, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хуулийг дагалдан гарах журмын төсөл боловсруулах, санал өгөх ажлуудыг гүйцэтгэж дуусаад байна.
3. Олон нийт рүү чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулж байна. Үүнээс сар бүрийн 20-ны өдөр иргэдэд хууль зүйн туслалцаа

үзүүлэх, “Хүүхдийн үгийг сонсьё” аян, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар оюутан, сурагчдад сургалт зохион байгуулах, Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрх зүйн шинэтгэлийн болон эрх зүйн боловсрол олгох ажлын талаар сурталчлах, шторк, нэвтрүүлэг хийх, мэдээлэх, Хууль, журмын төслийг иргэдээр хэлэлцүүлэх, Hotline /1800-1200/ утсаар иргэдээс нийслэлтэй холбоотой хууль тогтоомжийн талаар санал, хүсэлтийг хүлээж авах ажлууд үр дүнтэй тогтмол зохион байгуулж ажиллаж байна.

5.3 Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийг өөрчлөн зохион байгуулж, шинээр хоёр дүүрэг байгуулах ажлын талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу 1992 онд Улаанбаатар хотын район, хороодыг татан буулгаж, 12 дүүрэг (УИХ-ын тогтоол, 1992.08.18, №18) байгуулсан бөгөөд уг тогтоолоор байгуулсан Жаргалант, Туул, Гачуурт дүүргүүд нь бусад дүүргүүдээс хүн ам, нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн хувьд эрс ялгаатай, хэт жижиг, Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор” байх шинжийг хангах чадваргүй нь харагдсан тул 1995 онд УИХ-ын тогтоолоор (1995.01.16, №16) татан буулгаж, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх дүүрэгт тус тус нэгтгэсэн.

1990-ээд оны сүүлчээс орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдсэнтэй шууд холбоотойгоор нийслэлийн хүн амын тоо эрчимтэй өсөх болсон юм. Хотын хүн амын механик өсөлтийн ихэнх хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт ногдож байгааг Хүснэгт №1-ээс харууллаа.

Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн хүн ам 300.000 давж, хотын төвийн бусад дүүргийн хүн амаас даруй 101.5 – 167.6 мянгаар илүү (ойролцоогоор 1.5 - 2 дахин их), алслагдсан дүүргүүдийн хүн амаас 290.600 – 323.000 илүү (9 – 80 дахин их) болсон нь дүүрэгт үзүүлэх төрийн үйлчилгээний ачаалал, чанар, хүртээмжид хүчтэй нөлөө үзүүлэх болжээ.

Дүүргүүдийн хүн амын тоо (1992-2016, мянган хүн)

Дүүрэг	1992	1993	1995	2000	2005	2010	2015	2016
Баянгол	104.0	107.1	113.8	141.0	160.5	185.1	205.7	214.3
Баянзүрх	87.5	95.8	102.2	149.6	196.1	266.0	320.9	327.1
Сонгинохайрхан	115.0	118.1	123.7	158.6	204.6	252.3	307.2	315.8
Сүхбаатар	75.5	78.6	82.3	95.5	117.2	136.9	137.6	136.6
Хан-Уул	60.9	57.8	56.4	72.6	87.9	112.1	151.0	159.5
Чингэлтэй	84.8	85.2	89.6	108.7	130.5	147.4	154.8	158.0

Үүнээс гадна хотын суурьшлын газар нутгийн хэмжээ нэмэгдсэн, замын хөдөлгөөний ачаалал ихэссэн, төрийн үйлчилгээний нэр төрөл, цар хүрээ нэмэгдсэн зэрэг хөндлөнгийн олон шалтгааны улмаас төрийн үйлчилгээг хүргэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, төсөвт зардал нь хүн амын өсөлт, суурьшил, тэдгээрийн хэрэгцээ шаардлагад тэр бүр нийцэхгүй болсон.

Иймээс нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн зохион байгуулалтыг өөрчилж, шинээр дүүрэг байгуулах, төрийн үйлчилгээний ачааллыг төвийн бусад дүүргийн дундаж хэмжээнд хүртэл бууруулах, улмаар чанар хүртээмжийг нь нэмэгдүүлэх хэрэгцээ байна гэж үзээд уг өөрчлөлтийг хийх хууль эрх зүй, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн үндэслэлийг тодорхойлон дүүргийг хуваах шаардлага бий болж байна.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/546 дугаар захирамжаар Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийг өөрчлөн зохион байгуулж, шинээр хоёр дүүрэг байгуулах ажлын хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсэг хийх ажлын төлөвлөгөөг баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн 2 удаа хуралдаж, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн өнөөгийн нөхцөл байдал, 2 дүүрэг болгон хувааж өөрчлөн зохион байгуулагдсанаар төрийн үйлчилгээнд гарах үр дүнгийн тооцоо судалгааг гаргаж ирүүлэх үүрэг өгөгдсөн.

Үүний дагуу нийслэлийн байгууллагууд 2 дүүргийн өнөөгийн байдлын талаарх судалгааг ирүүлсэн боловч дүүргийг хуваасан хилийн цэсийг тодорхойлоогүй учир хуваасан зохион байгуулалтаар санал судалгаа ирээгүй байна.

Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 2 дүүргийг хуваасан хилийн цэсийг 3 хувилбараар гаргаж ирүүлээд байна.

5.4 Баянзүрх дүүргийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Засаг даргын томилгооны талаар

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн санал хураалт 2016 оны 10 дугаар сарын 19-ний өдөр явагдсан боловч тус дүүргийн 24 тойрог, 71 хэсэгт ирц хүрээгүй учир 10 дугаар сарын 23-ны өдөр нэмэлт санал хураалт явуулсан.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 41 төлөөлөгчтэй байхаас АН-аас нэр дэвшсэн 6 төлөөлөгч сонгуулийн холбогдох хуулийг зөрчсөн гэдэг шалтгаанаар Баянзүрх дүүргийн Сонгуулийн хороо нэр дэвшигчдийг нэрийн жагсаалтаас хассанаар МАН-аас 19, АН-аас 16 төлөөлөгч сонгогдсонд тооцож нийт 35 төлөөлөгчийн бүрэн эрх хүлээн зөвшөөрөгдсөн.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23.7-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын хуралдаанд Хурлын нийт төлөөлөгчийн олонх нь ирсэн бол хүчинтэйд тооцно” гэж заасны дагуу 35 төлөөлөгчийн 19 төлөөлөгч ирснээр хурал хүчинтэйд тооцно гэж заасны дагуу 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдааны тогтоол, тэмдэглэл зэргийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2017 оны Б/45 дугаар захирамжаар Э.Пүрэвдавааг чөлөөлж, 2017 оны Б/46 дугаар захирамжаар Э.Бат-Амгаланг томилсон шийдвэр гаргасан.

2017 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дээрх захирамжуудыг хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дагуу нийслэлийн Захиргааны хэргийн шүүхээс 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр нийслэлийн Засаг даргын 2017 оны Б/45, Б/46 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болгон шийдвэрлэсэн.

Одоогийн байдлаар Баянзүрх дүүргийн Засаг дарга Э.Пүрэвдаваа өөр ажилд шилжин ажиллахаар хүсэлт гаргасны дагуу Нийслэлийн Засаг дарга 2017 оны Б/171 дүгээр захирамжаар түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн болно.

5.5 Гэмт хэргийн нөхцөл байдал

Нийслэлийн хэмжээнд 2017 оны эхний 8 сард 57733 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь улсын хэмжээнд бүртгэгдсэн 120969 гомдол, мэдээллийн 47.7 хувийг эзэлж байгаа бөгөөд 36288 буюу 62.9 хувийг гэмт хэргийн шинжтэй, 21445 буюу 42.3 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байна.

- Нийт 120807 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урд оны мөн үетэй харьцуулахад булаах гэмт хэрэг 54.8, хүнийг санаатай алах гэмт хэрэг 31.5, танхайрах гэмт хэрэг 32.7, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний журам зөрчих гэмт хэрэг 15.7, бусдын биед гэмтэл учруулах гэмт хэрэг 2.8 хувиар тус тус буурсан. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 96.6, дээрэмдэх

гэмт хэрэг 62.8, хүчиндэх гэмт хэрэг 24.0, хулгайлах гэмт хэрэг 4.4, залилах гэмт хэрэг 1.6 хувиар өссөн.

№	Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо	Эзлэх хувь
1	Хулгайлах	4602	35.9
2	Бусдын биед гэмтэл учруулах	3316	25.9
3	Бусад төрлийн	1425	11.1
4	Залилах	1375	10.7
5	Танхайрах	569	4.4
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний журам зөрчих	542	4.2
7	Дээрэмдэх	438	3.4
8	Бусдыг амиа хорлоход хүргэх	293	2.3
9	Хүчиндэх	124	1.0
10	Бусдын эд хөрөнгийг булаах	52	0.8
11	Хүнийг санаатай алах	71	0.6
Нийт		120807	100

Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл урд оны мөн үеэс 177727 нэгжээр буюу 75.4 хувиар буурсан. Гомдол мэдээллийн 56294 буюу 97.5 хувийг шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 15656 буюу 43.1 хувийг 5 хоногт, 19518 буюу 53.8 хувийг 6 ба түүнээс дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 13293 буюу 54.4 хувийг 3 хоногт, 7827 буюу 32.0 хувийг 4 буюу түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.

Бүртгэгдсэн нийт хэргийн 7303 буюу 51.0 хувь нь хөнгөн, 3447 буюу 41.8 хувь нь хүндэвтэр, 1884 буюу 5.2 хувь нь хүнд, 173 буюу 2.1 хувь нь онц хүнд хэрэг эзэлж байна. Урд оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 16.8, хүнд гэмт хэрэг 210.4 хувиар өсөж, хүндэвтэр гэмт хэрэг -38.5, онц хүнд гэмт хэрэг -25.4 хувиар тус тус буурсан үзүүлэлтэй байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй нийт 9426 гэмт хэрэг бүртгэгдсэн үүнээс 3303 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоож гэмт хэргийн илрүүлэлт 32.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс илрүүлэлт 23.5 хувиар буурсан.

Гэмт хэргийн улмаас 12 аж ахуйн нэгж, байгууллага, 18028 иргэн хохирч, үүнээс 335 хүн нас барж, 4005 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, барсан хүн 8.4 хувиар, гэмтсэн хүний тоо 15.0 хувиар буурсан байна.

Гадаадын 59 иргэн гэмт хэргийн халдлагад өртөж хохирсныг өмнөх оны мөн үеэс 28.5 хувиар буурсан. Тухайлбал: БНХАУ-ын 25 иргэн, ОХУ-ын 9 иргэн, БНСУ-ын 11 иргэн, АНУ-ын 25 иргэн, бусад улсын 9 иргэн гэмт халдлагад өртөж хохирсон байна.

ЗУРГАА. ГАМШГААС ХАМГААЛАХ АЖЛЫН ТАЛААР

Нийслэлийн хэмжээнд 2017 оны эхний 8 сарын байдлаар объектын гал түймрийн 1796 дуудлагаар үүрэг гүйцэтгэж, аж ахуйн нэгж, төр иргэдийн 1,2 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, гал түймрийн аюулаас 600 иргэнийг аварсан. Ой хээрийн түймэр 18 удаа гарч нийт 112,6 га талбай өртөж, унтраах ажиллагаанд онцгой байдлын албанаас 769 албан хаагч, орон нутгаас 528 иргэн нийт 109 техник хэрэгсэлтэйгээр ажилласан. Нийслэлийн ногоон бүсэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017.07.20-ны өдрөөс 2017.07.31-ний өдрүүдэд урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл хяналтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улаанбаатар хот орчмын урсгал ус, тогтоол усанд иргэд живж осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Биокомбинатын гүүр - Сайханы саравч хүртэл Туул гол дагуу хөдөлгөөнт завьт эргүүлийг зохион байгуулж байна.

Малын гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр 9 дүүрэгт вакцинжуулалтын ажлыг 2017.01.30-ны өдрөөс эхлүүлэн 97,3 хувийн гүйцэтгэлтэй хийж дуусгасан. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг чиглэлээр 2017.02.03-ны өдрөөс Сонгинохайрхан, Багануур дүүргийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод ариутгал халдваргүйжүүлэлт хяналт шалгалтын постыг ажиллуулж, Улаанбаатар хот руу нэвтэрч буй 2421 тээврийн хэрэгслийг ариутгаж, 3141 ширхэг санамж сэрэмжлүүлэг тарааж, хяналт шалгалт хийж, гарал үүсэл мал эмнэлгийн бичиггүй тээврийн хэрэгслийг Улаанбаатар хот руу нэвтрүүлэхгүй арга хэмжээг авч ажилласан. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад Багануур, Багахангай, Налайх, Баянзүрх дүүргийн нийт 72935 толгой малыг хамруулсан.

Сонгинохайрхан дүүргийн 1, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2017 оны 07 дугаар сарын 23-ны өдөр малын гоц халдварт шүлхий өвчин илэрч, 1 дүгээр голомтын бүсийг 22 дугаар хорооны “Баянголын ам”-д, 2 дугаар голомтын бүсийг 1 дүгээр хорооны “Халзангийн ам”-нд тус тус хорио цээрийн дэглэм тогтоосон. Хорио цээрийн дэглэм тогтоосноос хойш 39 хоногийн хугацаанд 30 өрхийн 168 үхрийг зориудаар устгаж халдварын голомт дахь нийт 1197760 м² талбай, нэвтрэн өнгөрсөн 7533 автомашинд ариутгал халдваргүйжүүлэлт хийж гүйцэтгэсэн.

2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2 голомтын бүсэд 46 өрхийн 2332 толгой мал нутаглаж байгаа бөгөөд дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, байгууллагуудаас өдөр бүр 116 ажилтан, албан хаагч 43 нэгж техник хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэж, нийт 6 байгууллагын 67 ажилтан албан хаагч 16 нэгж техник хэрэгсэлтэйгээр ажиллаж байна. Голомтын бүсэд нийт 17500 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж гүйцэтгэсэн бөгөөд хөдөлгөөнт, хяналтын 17 пост/ цэг/ ажиллаж байна. 8-р сарын 30-ны байдлаар нийт 14 толгой үхрийг устгасан.

Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нийслэлийн нутаг дэвсгэрт гарсан малын гоц халдварт өвчин, ой, хээрийн түймэр, үер усны гамшиг осол, түүний үр дагаврыг арилгахад 634.7 сая төгрөгийг олгосон.

Цаашид малын гоц халдварт өвчний шинж тэмдэг дахин илрэхгүй нөхцөлд Нэгдүгээр голомтын бүсийн хорио цээрийн дэглэмийг 2017 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр, хоёрдугаар голомтын бүсийн Хорио цээрийн дэглэмийг 09 дүгээр сарын 09-ний өдөр тус тус цуцлахаар төлөвлөн ажиллаж байна. Ус сувгийн удирдах газраас цэвэр усны хангамжийг зөөвөрлөж, хүнсний дэлгүүрүүдийг бараа бүтээгдэхүүн, хоол хүнсийг нийлүүлэлтийн хангалтыг зохион байгуулж байна. Хаан банкны явуулын АТМ-ыг хязгаарлалтын бүсэд байрлуулж иргэдийг бэлэн мөнгөөр худалдан авах нөхцөлийг бүрдүүлсэн. ОБЕГ-ын Аврах тусгай ангийн тусгай үүргийн халдваргүйжүүлэлтийн ДДА-3Б техникээр зайлшгүй шаардлагатай иргэдийг ариутгал халдваргүйжүүлэлт хийж голомтын бүсээс гаргаж байна. Одоогийн байдлаар гамшгийн голомтод дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 10 гаруй сая төгрөг зарцуулаад байна.

Нийслэлд байгалийн голомтот болон хүн, мал амьтны гоц халдварт өвчний халдвар зөөгдөн орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн 6 дүүргийн авто тээврийн шалган бүртгэх товчоодод 8 байнгын хяналтын цэгт, 9 хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦ БОЛОН САНХҮҮ,
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

/2017 оны эхний 8 сарын байдлаар/

1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ
2. НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААР
3. НИЙСЛЭЛИЙН 2017-2018 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТАЛААР
4. 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТАЛААР
5. НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ЖИЛИЙН АЖЛЫН ТАЛААР
6. ГАМШГААС ХАМГААЛАХ АЖЛЫН ТАЛААР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР